

ТҮМЭНЦОГТ СУМЫН 2021 ОНЫ 10 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Засаг даргын захирамж 12, ЗДТГ-ын даргын тушаал 0, ирсэн бичиг-18, Засаг даргын явсан бичиг-25, ЗДТГ-ын даргын явсан бичиг-3, өргөдөл гомдол-0, Төрийн үйлчилгээний оператороос төрлийн лавлагаа өгч иргэн төвтэй-төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Хууль эрх зүйн чиглэлээр:

Ковид-19 цар цахалтай холбоотой Улсын Онцгой комиссын албан даалгавар, ЗГ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч цахимаар 56 төрлийн мэдээллийг сумын 3 группээр дамжуулан иргэдэд хүргэсэн.

Шинэчлэгдэн найруулагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд цахимаар 3 төрлийн мэдээлэл 20 гаруй удаагийн давтамжтай хүргэсэн.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөл байгуулж худалдаа үйлчилгээ эрхэлдэг ААНэгжүүдэд хяналт тавьж, заавар зөвлөмж, сургалт зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Ажил хайгч 9 иргэдийн мэдээллийг “LIMS” праграммд шинэчилж бүртгэсэн.

Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд болон байнгын ажлын байраар хангагдсан 4 иргэнийг мэдээллийн санд бүртгэсэн.

Залуучуудын “ОРОЛЦОО” төсөлд хамрагдсан 6 иргэний 14 хоногийн дадлагын ажилд 09 дүгээр сарын 27 өдрөөс эхлэн ЗДТГазрын архив бичиг хэргийн мэргэжилтэн дээр 1 иргэн, Татварын Улсын байцаагч дээр 1 иргэн, Уул уурхайн “Говьмастер” ХХК-д тогоочоор 1 иргэн, “Монгол жү юань ли” ХХК-д 1 иргэн тогоочоор, Сүхбаатар аймагт худалдааны зөвлөхөөр 1 иргэн, Улаанбаатар хотод 1 иргэн дадлагаар гарч дадлагат гарч дууссан 2 иргэний материалыг бүрдүүлэн мэргэжилтэнд хүргүүлсэн. 1 иргэн нь ковид-19 цар дахал хүрч дадлагын хугацаа сунгагдсан. Оролцоо төсөлд хамрагдсан 6 иргэнийг ажил хайгчаар мэдээллийн санд бүртгэж цаашид ажлын байранд зуучлах тал дээр анхаарч ажиллаж байна.

Санхүүгийн дэмжлэг болох Итгэлийн зээлд хамрагдсан иргэн төлөвлөгөөний дагуу эргэн төлөлтийг хийлгэх ажлыг эрчимжүүлж төсөл хөтөлбөрт хамрагдсан өрх иргэдийг эргэн төлөлтийг хугацаандаа хийхийг анхааруулж ажилласан.

Сүхбаатар аймагт 2021.10.08-09-ны өдөр хүртэл 2 хоног зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд-Сүхбаатарт үйлдвэрлэв 2021” үзэсгэлэн худалдаанд санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаа явуулж байгаа өрх иргэдийг хамруулсан. Үүнд:

1. ХБИ-ний ажлын байрыг дэмжих төсөлд хамрагдсан Э.Сансармаа “Оёмол” бүтээгдэхүүнээр оролцож ХХҮГ-ын нэрэмжит “Шилдэг үйлдвэрлэг” шагнал шагнагдаж 520,000 төгрөгний борлуулалт
2. “Ахмадын ажлын байрыг дэмжих төсөл”-д хамрагдсан А.Баатархуяг “Шилдэг модон эдлэл үйлдвэрлэгч”-ээр шалгарч 1-р байранд орж 500,000 төгрөгний борлуулалт
3. “Ажлын байрыг дэмжих төсөл”-д хамрагдаж үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байгаа Д.Тунгалаг “Шилдэг оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр шалгарч 1-р байранд орж 320,000 төгрөгний борлуулалт

4. Ажлын байрыг дэмжих төсөлд “Сүү, сүүн бүтээгдэхүүн” үйлдвэрлэл чиглэлээр хамрагдсан Э.Ууганболор амжилттай оролцож 131,000 төгрөгний борлуулалт
5. “Ажлын байрыг дэмжих төсөл”-д оёдол эсгүүрээр хамрагдсан Т.Хэрлэнцэцэг өөрийн биеэр оролцох боломжгүй ч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хүлээлгэн өгч амжилттай оролцон 75,000 төгрөгийн борлуулалт хийсэн.
6. ОНОТХҮ-ний буцалтгүй 1 сая төгрөгний төсөлд “Хүнсний ногоо” тариалалтаар дэмжлэг авсан Р.Бэрцэцэг амжилттай оролцож 100,000 төгрөгний борлуулалт хийсэн.

Тус үзэсгэлэн худалдаанд сумын дүнгээрээ амжилттай оролцож “Гран при” тэргүүн байранд орж нийт 1646,000 төгрөгний борлуулалт хийж өрхийн орлогыг нэмэгдүүлж үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг аймгийн хэмжээнд сурталчилж дэмжлэг авсан 2 иргэнийг телевизийн ярилцлага өгүүлсэн.

Сүхбаатар аймагт ХХҮГазраас зохион байгуулагдаж байгаа “Үсчин”, “Гоо сайхан”-ы 14 хоногийн сургалтанд хамрагдах хүсэлтэй иргэдэд цахимаар мэдээлэл хүргэн зар тавьсны үр дүнд нийт 11 иргэн бүртгэж 3 иргэнийг хамруулсан.

2021.10.04-ны өдөр Улаанбаатар хотоос “Дарь-Овооны эзэд” төрийн бус байгууллагаас мэргэжилтэн нар ирж сумын ажилгүй болон идэвхитэй ажил хайж байгаа иргэд, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг ажилгүй хөдөлмөр эрхлээгүй иргэд, зорилтот бүлгийн нийт 41 иргэнд ажил мэргэжилийн чиг баримжаа олгох 1 өдрийн сургалт өгсөн.

Малчин өрхийг малжуулах төсөлд хамрагдах хүсэлтэй 1-р багийн иргэн А.Давгадоржид 4 сая төгрөгний мал хүлээлцэх ажлыг зохион байгуулж гэрээ болон холбогдох материалыг мэргэжилтэнд хүргүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан 2 иргэний төслийг хүлээн авч мэргэжилтэнд хүргүүлсэн.

Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах төслийг нөөц бааз суурь дээрээ тулгуурлан сумын Засаг дарга 600000 төгрөгний үнэ бүхий 10 шуудай 400 кг төмсийг зорилтот бүлгийн 10 иргэнд хувиарлан өгч тариулж “Ахмад мэргэжилтэнээр зөвлөн туслах үйлчилгээ” үзүүлж 0,5 га талбайд тариалсан. Тухайн иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн ахмад мэргэжилтний тайлан цагийн бүртгэл, нэхэмжилэхийг мэргэжилтэнд хүргүүлсэн.

Аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдах 6 иргэний мэдээллийг бүртгэж мэргэжилтэнд хүргүүлсэн.

“Булаг шанд хашиж хамгаалах” нийтийг хамарсан төслийн ажлын эхлүүлэх үүднээс булаг шанд хаших сургааган 100 ширхэг модыг дадал сумаас авчруулах ажлын сумын Засаг дарга зохион байгуулж ажиллах хүчний жагсаалтыг танилцуулсан.

“Түмэнцогт суманд үйлдвэрлэв” борлуулалтын цэгт 13 иргэний бараа бүтээгдэхүүнийг борлуулж нийт 1250.000 төгрөгний борлуулт хийж тус цэгийн цахим хуудсанд мэдээ, мэдээлэл оруулж иргэдэд бараа бүтээгдэхүүнийг сурталчилж ажиллаж байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

ОНОТХҮ-ний төсөлд “Компьютер, канон”-ний чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлтэй амьжиргааны түвшин доогуур орлоготой өрх болон хорих ангиас суллагдаж ирээд ажил хөдөлмөр эрхэлдэггүй 2 өрхийн 1 бүлгийн төслийг холбогдох баримт бичгийн хамт явуулсан.

Хүнсний эрхийн бичгийн олголттой холбоотой хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж байгаа дэлгүүрийн прагромм хөгжүүлэлтийг хийлгэж байна.

Амьжиргааг дэмжих зөвлөлийг тухайн сард 3 удаа хуралдуулж 7 төрлийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж холбогдох мэргэжилтэнд хурлын тэмдэглэлийг материалын хамт хүргүүлж ажилласан. Үүнд:

1. Галын аюулын улмаас орон гэргүй болсон 1 өрх
2. 0-18 насандаа бүтэн өнчин болж 18-24 насандаа 1 удаагийн 1200000 төгрөгийн тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан 3 иргэний материал
3. ОНОТХҮТөсөлд хамрагдах хүсэлт гаргасан 1 бүлгийн төсөл
4. Ганц бие ахмад настны асаргааны тэтгэмжид хамрагдах хүсэлтэй 1 иргэний материал
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмжийн сунгалт 1 иргэн
6. Ахмад настны асаргааны тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан 1 иргэн
7. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс 1 жилээс дээш нийгмийн даатгалын шимтгэл төлөгдсөн 4 өрхийг түтгэлзүүлэх эсэх

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн тулгалтийг цаг тухай бүрт хийн нөхөн олголтыг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллаж байна.

10 сарын тэтгэвэр тэтгэмжийн олголт:

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	35	10080000
2	Байнгын асаргаатай ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэн, бүтэн өнчин хүүхэд асардаг иргэний тэтгэмж	38	3349350
3	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд	8	1988130
4	Тэжээгчээ алдсны тэтгэвэр	10	3068000
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламж	4	80000
6	Жирэмсэн эхийн тэтгэмж	18	720000
7	0-3 хүртэлх насны хүүхэд асарч байгаа эхийн тэтгэмж	123	6043547
8	Харъяалалгүй ахмадын хүндэтгэл	190	1900000
	Нийт	426	27229027

БУСАД:

2021 оны 09 сарын 27-ны өдөр ХХҮГазраас зохион байгуулсан онлайн хурлаар өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж ажилласан. Үүнд:

1. ОНОТХҮ-ний төсөлд 1 бүлгийн төсөл
2. Харъяалалгүй ахмадын жагсаалтыг явуулж мэдээллийн санд бүртгэсэн.
3. Шинэ ажлын байраар хангагдсан иргэдийг мэдээллийн санд бүртгэсэн.
4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй байгаа ажлын 1 болох Ажил мэргэжилийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулж 41 иргэн хамруулсан.
5. Оролцоо төслийн хүрээнд дадлагат гарч дууссан 2 иргэний тайлан болон холбогдох баримт бичгийг хүргүүлсэн.
6. ХБИ-ний төсөлд 2 иргэний төсөл явуулсан.
7. Малжуулах төсөлд 1-р багийн малчныг хамруулж малыг хүлээлцсэн.

Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Шилэн дансны тухай хуулийн 5-р зүйлийн 5,3 дах заалтыг хэрэгжүүлэх үүднээс 2021 оны 10-р сарын мэдээг шилэн дансны вейб сайтад байршуулсан Сангийн яам болон холбогдох хэлтэс агентлагт хувиарын дагуу мэдээг хүргүүлэн ажилласан.

Төсвийн байгууллага болон төсөл сан, төрийн өмчит аж ахуйн тооцоот байгууллагуудын 2021 оны 3-р улирлын санхүүгийн тайланг гаргуулан хянан баталгаажуулж Сангийн яамны сайтад хугацаанд илгээсэн.

Татвар , нийгмийн даатгалын тайланг сайтуудад нь хугацаанд нь илгээсэн.

Статистикийн хэлтэст сарын болон улирлын мэдээг хугацаанд хүргүүлсэн.

Орон нутгийн орлогын биелэлт: / 10 сарын дүнгээр мян.төг /

• Үйл ажиллагааны орлого	10900,4
• Шууд бус орлого	3972,7
• Малын албан татвар	27290,4
• Хөрөнгө борлуулсаны орлого	2445,5
• Хөрөнгийн орлого	29737,1
• Буу	1036,0
• Улсын тэмдэгтийн хураамж	1973,3
• Хог хаягдал	3399,9
• Хүү торгуулийн орлого	34484,5
• ТТАМ	1070,0
• Бусад нэр заагдаагүй орлого	48039,8
• Газар	12585,5

- Ан амьтны нөөц ашигласны хураамж
- Дүн

54604,8
231539,9

ERP-ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН
НЭГДСЭН СИСТЕМ-д ЗДТГ-ын 26 албан хаагчид хамрагдан ашиглаж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
Б.Ариунжаргал /ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН/